

МОНГОЛ, АНУ-ЫН ДИПЛОМАТ ХАРИЛЦААНЫ ТҮҮХИЙН АСУУДАЛД

У. Лхагвасүрэн*

Д*ипломат харилцаа үүссэн буюу 1987 он хүртэлх харилцаа:*

Монгол Улс, АНУ нь хоёр өөр тивийн, газар зүйн хувьд алслагдсан улсууд юм. Монгол улс ХҮШ зуунаас ХХ зууны эхэн хүртэл Манж улс, түүний дараагаар 1990 он хүртэл Зөвлөлт Холбоот улсын улс төр ба эдийн засгийн нөлөөнд оршин тогтнож байв.

XIX зууны сүүл ХХ зууны эхээс Монгол Улс АНУ-тай улс төр, эдийн засгийн харилцаа үүсэх нөхцөл байдал бий болжээ. 1899-1900 онд АНУ-аас Хятадад хэрэгжүүлж эхэлсэн “Нээлттэй хаалганы бодлого”-ын ачаар америкчуудад Монголын үүд хаалга нээгдэв.

Монгол улсын эдийн засаг АНУ-ын анхаарлыг төдийлөн татаж чадахгүй байв. Учир нь манай зах зээл жижиг төдийгүй Хятадын том зах зээл илүү ашигтай байжээ. Америк бараа Хятадаар дамжин Монголд орж ирэх болов. Америк худалдаачдын сонирхлыг Монголын хөдөө аж ахуй, малын гаралтай бүтээгдэхүүн, ан агнуур, байгалийн баялаг ихээхэн татаж байв. 1907 оноос Америк пүүсүүд Нийслэл Хүрээнд байгуулагдаж эхэлжээ.

ХХ зууны эхээр Монгол улсыг Богд хаан удирдаж байв. Монголчууд 1911 оны хувьсгалаар Манжийн дарлалыг унагаасан ч зөвхөн Төвд улс түүний тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн тул олон улсаар зөвшөөрүүлэх шаардлага Богд хааны засгийн газарт тулгарав. Ийм учраас 1913 онд Богд хаан Бээжин дэх Америкийн консулаар дамжуулан дипломат харилцаа тогтоох санал тавьж байжээ. Гэвч ямар ч хариу илгээгээгүй байна. 1913 оны 12-р сард америкийн дипломатч Виллиам Вүүдвил Рокхилл Нийслэл Хүрээнд айлчлан Монголын эрх баригч нартай уулзан манай орны гадаад, дотоод байдалтай танилцжээ. Энэ уулзалтын үеэр Оросын консул Александр Миллер орчуулагчийн үүрэг гүйцэтгэж байсан тул Монголын эрх баригчид өөрийн байр сууриа илэрхийлж чадаагүй байна¹.

1914 оны эхээр Монголын талаас албаны хүмүүс Бээжин дэх АНУ-ын элчин сайдын яамтай холбоо барьж хэд хэдэн асуудал хөндсөний нэг нь Өргөө хотод Консулын газар нээх тухай яригдсан байдаг. 1918 онд Монголын засгийн газар америкийн талд Нийслэл Хүрээнд консул байгуулах санал тавьсан боловч АНУ нь Япон, Хятад, Оросын эсэргүүцэлтэй тулгарснаас үүдэн Вашингтоноос тохиромжтой цаг үе биш

*МУИС, ОУХС-ын багш, докторант

1. Н. Ишжамц “АНУ-аас Монголын хувьд явуулсан бодлого, Монгол-америкийн харилцаа (1900-1987)” х.5-13 УБ, 1999

гэсэн хариу өгчээ. АНУ нь Монгол улсад консулын газраа нээж чадалгүй Өвөр Монголын Хаалган хотод буюу одоогийн Жанчхүү хотод нээжээ. Энэхүү консулын газар нь Америк Монголын харилцаа ойртох эхний алхам болов.

1920 оны 4 сард америкийн дипломатч Чарльз Эбэрхард 5 хоногийн хугацаатай Монголын дотоод байдалтай танилцах зорилготой айлчлав. Жалханз хутагт түүнд албан ёсоор тусламж хүссэн захиа илгээсэн боловч хариу аваагүй байна. 1921 оны 7 сарын 11-ний хувьсгалаар Монгол улс болшевикуудын тусламжтай тусгаар тогтнолоо зарласан байна. Үүний дараагаас болшевикуудын дэмжлэгтэйгээр Монгол Ардын Хувьсгалт Нам байгуулагдан 1924 оноос засгийн газрыг удирдах болжээ. Ийнхүү Монгол улс капиталист бус социалист дэглэмийг сонгов. Коминтерний нөлөө нэмэгдэх тусам америкчуудыг хавчих, гадуурхах явдал ихсэв. Монгол Ардын Хувьсгалт Нам америкийн дипломатуудыг итгэж үл болох этгээдүүд хэмээн үзэж америкаас ирсэн хэнд ч итгэж үл болно хэмээн зарлажээ. Түүнчлэн америк худалдаачид Нийслэл Хүрээг орхин явсан байна. Ийнхүү Монгол улс улс төр төдийгүй эдийн засгийн хувьд улам хаалттай болсон байна. 1930-аад оноос АНУ Хятадын Гоминданыг дэмжин хамтран ажиллах болжээ. Энэ нам нь Монголыг өөрийн нэг хэсэг хэмээн үздэг байв. АНУ мөн адил Монголыг Хятадын нэг хэсэг гэхдээ ЗХУ-ын хүчтэй нөлөөн доорхи дагуул улс хэмээн үзэх болжээ².

Дэлхийн II дайн төгсгөл үед их гүрнүүд АНУ болон Их Британи ЗХУ-ыг дайнд оруулахыг хүсч байв. Харин ЗХУ дайнд орох нөхцөлдөө Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх талаар оруулах хүсэлтэй байв. АНУ-ын ерөнхийлөгч Франклин Делано Рузвельт дэд ерөнхийлөгч Хэнри Агард Воллисийг Сибир болон Хятад луу томилов. Энэхүү айлчлалынхаа үеэр 1944 оны 7 сарын 2-нд Монгол улсад ирж манай орны бодит байдалтай танилцан эерэг бодолтой буцжээ. 1945 оны Ялтын хурлын үеэр ЗХУ Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх талаар санал тавихад АНУ, Их Британи татгалзах зүйлгүй зөвшөөрөв. Гэвч Хятадын зөвшөөрөл хэрэгтэй байв. 1945 оны 10 сарын 20-нд болсон бүх нийтийн санал асуулгаар монголчууд 100 хувь тусгаар тогтнолын төлөө саналаа өгсөн байна. Ийнхүү Монгол улсыг тусгаар тогтнолоо баталгаажуулахад Ялтын хурал ба Их гурван гүрний (АНУ, ЗХУ, Их Британи) шийдвэр маш чухал үүрэг гүйцэтгэв.

Дэлхийн II дайны дараа олон улсын байдал ихээхэн өөрчлөгдөж улс орнууд хоёр системд хуваагдаж хүйтэн дайн эхлэв. Хоёр системийн зөрчилдөөнөөс болж 1960 он хүртэл Монгол Улс Америкийн Нэгдсэн Улс хооронд дипломат харилцаа тогтоох талаар огт хөндөгдөж байсангүй.

2. М. Хурметхан “Монгол улс Америкийн Нэгдсэн Улсын харилцаа, хамтын ажиллагаа 1945-1999” х. 9-17 УБ, 2000

Монгол улс АНУ, ЗХУ, Их Британи мөн Хятадаар тусгаар тогтнолоо зөвшөөрүүлснийхээ дараа Нэгдсэн Үндэсний Байгууллагад элсэн АНУ-тай дипломат харилцаа тогтоохыг хичээх болов. 1946 оноос эхлэн Монгол улс хүсэлт гаргасан боловч АНУ болон Хятад улс эсэргүүцэж байв. Эцэст нь 9 удаагийн өргөдлийн дараа 1961 оны 10 сарын 27-нд Монгол улс НҮБ-ын гишүүн болжээ³.

1960-1970-аад оны үед Монгол Улс болон АНУ-ын зүгээс дипломат харилцаа тогтоох хэд хэдэн удаагийн нааштай санал гарч байсны нэг жишээ нь 1961 оны 8 сарын 2-нд АНУ-ын Москва дахь хэргийг түр хамаарагч Эдуард Фрийрс Монголын элчин сайд С. Лувсантай уулзан АНУ Монгол улстай дипломат харилцаа тогтоох хүсэлтэй байгааг илэрхийлсэн явдал юм. Гэвч Тайваны засгийн газар, Тайван дахь Хятадын үндэстний үзэлтнүүд АНУ-ын талд шахалт үзүүлэн энэ асуудалд саад болсон байна.

Монгол улс НҮБ-ын гишүүн болсны дараагаас НҮБ-ийн дэргэдэх Байнгын Төлөөлөгчийн газраараа дамжуулан АНУ-тай худалдааны болон соёл шинжлэх ухааны харилцаагаа явуулж байв⁴.

1973 оны 3 сарын 29-нд албан ёсоор АНУ Монгол улстай дипломат харилцаа тогтоох саналаа илэрхийлэв. Монголын тал дипломат харилцаа тогтоох талаар цахилгаан мэдээг 1973 оны 4 сарын 18-нд НҮБ-ийн дэргэдэх Байнгын Төлөөлөгчийн газар луугаа илгээсэн боловч Прагад алдагджээ. Энэ нь их гүрний дээрэнгүй бодлогыг харуулж байв⁵. 1973 оны 4 сарын 29-нд Монголын Гадаад Явдлын Яамны Сайд Л. Ринчин ЗХУ Монголыг АНУ-тай дипломат харилцаа тогтоох талаар ямар байр суурьтай байгааг Гадаад Явдлын Яамны Сайдын орлогч Василий Васильевич Кузнецовоос асуухад эхлээд энэ талаар Төв Хороонд зөвлөлдөх хэрэгтэй гэжээ. Тэр оны намар Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал Леонид Брежневийн туслахтай уулзахад АНУ-тай дипломат харилцаа тогтоохоо түр азнана уу гэсэн хариу авчээ. 1973 оны 11 сарын 9-нд АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Хэнри Киссенжер Монгол улстай тогтоох дипломат харилцаа сүүлийн шатандаа явж байна хэмээн мэдэгджээ. ЗХУ-ын Гадаад Явдлын Яамны Сайд Андрей Андреевич Громыко 1975 онд Монголын Гадаад Явдлын Яамны Сайд Л.Ринчинтэй уулзахдаа АНУ-тай дипломат харилцаа тогтоох асуудал нь маш төвөгтэй асуудал бөгөөд америкчуудын зорилго тагнуул хийж Монголыг хүнд байдалд оруулж мэднэ хэмээн эсэргүүцэж байгаагаа илэрхийлэв. Ийнхүү дипломат харилцаа тогтоох асуудал дахин хойшлогдов. Ингэж удааширхад ЗХУ-ын хориг төдийгүй Монголын удирдагчдын идэвхигүй байдал, ЗХУ-ын аясаар байсан нь нөлөөлж байв.

3. Н. Ишжамц “АНУ-аас Монголын хувьд явуулсан бодлого, Монгол-америкийн харилцаа (1900-1987)” х.37-51 УБ, 1999

4. Н. Ишжамц “АНУ-аас Монголын хувьд явуулсан бодлого, Монгол-америкийн харилцаа (1900-1987)” х. 53-57 УБ, 1999

5. М. Хурметхан, “Монгол улс Америкийн Нэгдсэн Улсын харилцаа, хамтын ажиллагаа 1945-1999” х. 34. УБ, 2000

1985 оноос ЗХУ-д Михаил Горбачев ил тод байдал, өөрчлөн байгуулалтыг эхлүүлснээр улс төрд ч асар их өөрчлөлт гарсан юм. 1986 оны 1 сарын 23-нд ЗХУ-ын Гадаад Явдлын Яамны Сайд Эдуард Шверднадзе Монголд айлчлах үеэрээ АНУ-тай дипломат харилцаа тогтоох тохиромжтой үе хэмээн ЗХУ-ын байр суурийг илэрхийлэв. 1986 оны 7 сараас АНУ-ын Нью Йорк хотноо дипломат харилцаа тогтоох 2 талын хэлэлцээр эхлэв. Ингээд 1987 оны 1 сарын 23-нд Монгол улс АНУ-тай дипломат харилцаа тогтоов⁶.

Шилжилтийн үеийн харилцаа:

1989 оноос ЗХУ болон Зүүн Европт ардчилалын хөдөлгөөн өрнөж Монгол Улс ч энэхүү эрс шилжилтийн эргүүлгэнд татагдан орсон юм. 1990-ээд он Монголын эдийн засгийн хувьд тун хэцүү үе байсан бөгөөд гадаад орнуудаас тусламж авах шаардлагатай болжээ. Энэ үед ардчилсан замаар хөгжихийг эрмэлзэж байсан Монгол Улсыг Европын болон бусад ардчилсан орнууд, мөн АНУ дэмжин эдийн засгийн болон хүмүүнлэгийн тусламж үзүүлж эхлэв⁷.

Монгол улс ЗХУ-ын улс төр, эдийн засгийн нөлөөнөөс гарснаар хөгжлийн шинэ үе шат нээгдэв. Америкийн бизнесмэнүүд Монголын малын гаралтай бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуурыг ихээхэн сонирхож байсан юм. Монгол, Америкийн хооронд 1991 онд худалдааны гэрээ мөн 1994 онд хөрөнгө оруулалтын гэрээ хийгдэв.

1990 онд АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Жеймс Бэйкер Монголд айлчлав. Энэхүү айлчлал нь Монгол, Америкийн харилцааны шинэ үе шатыг эхлүүлжээ. Айлчлалынхаа үеэр “гуравдагч хөрш” хэмээх нэр томъёог гаргаж иржээ. Энэхүү ойлголт нь Монгол Америкийн цаашдын харилцааны чиглэлийг тодорхойлсон юм. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Бушын урилгаар 1991 оны 1-р сарын 20-нд Монголын анхны ерөнхийлөгч П. Очирбат АНУ-д айлчлав. Ж.Буш эдийн засгийн хамтын ажиллагаа болон соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээ байгуулах болно хэмээн зарлажээ. 1991 оны 6 сарын 14-нд Монгол улсын ерөнхий сайд Д.Бямбасүрэн АНУ-д айлчлан шилжилтийн эдийн засгийн талаар мөн АНУ-ын хөгжлийн (USAID) тусламжийн талаар ярилцсан байна. АНУ 1991 онд Монгол улсыг Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банкинд гишүүнээр элсэхэд дэмжлэг үзүүлсэн байна.

1995 оны 9 сарын 7-нд АНУ-ын тэргүүн хатагтай Хиллари Родхам Клинтон Хятадад хийсэн айлчлалаасаа буцаж явахдаа Монголд зочилжээ. Клинтон АНУ-ын UNICEF байгууллага 1 сая долларын тусламжийг

6. М. Хурметхан, “Монгол улс Америкийн Нэгдсэн Улсын харилцаа, хамтын ажиллагаа 1945-1999” х. 33-40 УБ, 2000

7. Mongolia and the United States: A Long Way in a Short Time, <http://www.americanambassadors.org/index.cfm?fuseaction=Publications.article&articleid=244>

хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөрт зориулж байгааг мэдэгдэв⁸. Монгол улсын ерөнхий сайд М.Энхсайхан 1996 оны 10 сарын 2-нд АНУ-д айлчлан АНУ-ын төрийн нарийн бичгийн даргын орлогч Строб Талботтой уулзжээ. Тэрээр хоёр орны эдийн засгийн болон улс төрийн харилцааны талаар ярилцсан байна. Мөн онд АНУ-ын сенатор Арлен Ж.Спектор Монголд айлчлан парламентын гишүүдтэй уулзжээ. 1998 оны 5 сарын 2-нд АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Маддлен Корбелова Олбрайт Монголд айлчлав. Тэрээр Монголын ардчилалыг сайшаан магтаж АНУ цаашдаа харилцаагаа улам их гүнзгийрүүлэх хүсэлтэй байгааг илэрхийлжээ⁹.

XXI зууны эхэн үеийн харилцаа

Монгол улс АНУ-тай дипломат харилцаа тогтоосноос хойш 2 орны төлөөлөгчид харилцан айлчлал хийж хоорондын харилцаагаа улам бэхжүүлэв. АНУ-ын томоохон албан тушаалтнуудын хийсэн айлчлал Монголын нэрийг олон улсын тавцанд өргөв. 2001 онд Монгол улсын ерөнхий сайд Н. Энхбаяр АНУ-д айлчлал хийв. Айлчлалын зорилго нь ардчилалыг дэмжин улс төрийн хамтын ажиллагааг бэхжүүлж, эдийн засгийн болон хүмүүнлэгийн тусламжийг нэмэгдүүлэх байв.

2003 оноос Монголын зэвсэгт хүчин АНУ-ын цэргийн удирдлага дор Ирак мөн Афганистанд алба хааж эхлэв. Өнөөдрийн байдлаар Монгол Улсаас энхийг сахиулах олон улсын ажиллагаанд 7000 орчим дайчин оролцжээ. Дайчид Афганистан, Судан, Чад, Сьерра Леон зэрэг орнуудад алба хаасан. Ингэснээр Монгол Улсын нэр хүнд олон улсад өссөн төдийгүй зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг чадавхижуулах, дипломат аргаар улсын аюулгүй байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлжээ.

2005 оны 7 сарын 15-нд Монгол улсын ерөнхийлөгч Н. Багабанди АНУ-д албан ёсны айлчлал хийв. АНУ-ын ерөнхийлөгч Буш Ирак болон Афганистан луу цэргээ илгээсэнд талархлаа илэрхийлжээ. Мөн цаашид цэргээ илгээн 2 орны эдийн засгийн харилцаа болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тал дээр хамтран ажиллахаар тохиролцов. 2005 оны 11 сарын 21-нд АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш Монгол улсад айлчилав. Тэрээр Монгол улсад айлчилсан анхны АНУ-ын ерөнхийлөгч юм. Түүнтэй хамт АНУ-ын тэргүүн хатагтай Лара Буш, төрийн нарийн бичгийн дарга Кондолиза Райс, аюулгүй байдлын зөвлөх Стефен Жон Хадлей гэх мэт өндөр албан тушаалтнууд ирсэн юм. Буш ардчилалын үйл явцыг сайшаан магтан тусламж дэмжлэгээ нэмэгдүүлэхээ мөн 11 сая долларын тусламжийг Батлан Хамгаалахын салбарт өгөх болсноо мэдэгдэв.

8. Д. Жамбалдорж, Т. Бярзана, Д. Баярсайхан “Монгол улс Америкийн Нэгдсэн Улсын харилцаа хамтын ажиллагааны үүсэл, хөгжлийн түүхэн он жилүүд” х. 24-31 УБ, 2008

9. М. Хурметхан, “Монгол улс Америкийн Нэгдсэн Улсын харилцаа, хамтын ажиллагаа 1945-1999” х. 54-56 УБ, 2000

2007 оны 10 сарын 24-нд Монгол улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр АНУ-д айлчлал хийжээ. Хоёр улсын ерөнхийлөгч Мянганы Сорилтын Сангийн гэрээнд гарын үсэг зурсан юм. Энэхүү хөтөлбөр нь 5 жилийн хугацаанд хэрэгжин 285 сая долларын өртөгтэй ядуурлыг бууруулж эдийн засгийн хөгжлийг дэмжих, авилгатай тэмцэх, эрүүл мэнд ба боловсролыг дээшлүүлэх, төмөр зам болон дэд бүтцийг сайжруулах зорилготой билээ¹⁰. Энэхүү хөтөлбөр нь АНУ-аас Монгол Улсад үзүүлж буй тусламжийн хэмжээг даруй хоёр дахин нэмэгдүүлсэн юм. Мянганы Сорилтын Корпорацийн гэрээ нь 2008 оны 9 сараас 2013 оны 9 сар хүртэл албан ёсоор хэрэгжсэн юм. Мянганы Сорилтын Сангийн тодорхой хөтөлбөрүүд нь дэд бүтэц, эрүүл мэнд, хөрөнгийн эрх, мэргэжлийн боловсрол сургалт, эрчим хүч, байгал хамгаалал зэрэг салбаруудад амжилттай хэрэгжүүлэв.

Монгол улсын дараагийн ерөнхийлөгч Ц. Элбэгдорж 2011 оны 6 сарын 16-нд АНУ-д айлчлал хийв. АНУ-ын ерөнхийлөгч Барак Обаматай хийсэн уулзалтын үеэр дипломат, эдийн засаг, батлан хамгаалахын харилцааг өргөжүүлэх, ардчилал ба эрх чөлөөг эрхэмлэх, хүний эрхийг дээдлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хоёр улсын хоорондын найрсан харилцааг бэхжүүлэх талаар тохиролцлоо¹¹.

АНУ-ын дэд ерөнхийлөгч Жон Байден 2011 оны 8 сарын 22-нд Монгол улсад айлчлал хийв. Монгол улсын ерөнхий сайд С. Батболдтой хийсэн уулзалтаар улс төр, эдийн засаг, соёл урлагийн харилцааг бэхжүүлэх талаар ярилцав. АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон 2012 оны 7 сарын 7-нд Монгол улсад айлчлал хийв. Айлчлалын үеэр олон улсын эмэгтэйчүүдийн форумд оролцож ардчилсан нийгэмд эмэгтэйчүүдийн оролцоо чухал болохыг тодотгов.

Дүгнэлт

Монгол улс АНУ-ын харилцааны эхлэл үе буюу XIX зууны эхэн үед манжийн дарлалд байсан хөгжил буурай Монгол улс АНУ-ын анхаарлыг төдийлэн татаж чадахгүй байв. Хэдийгээр 1907 оноос Америкийн худалдааны пүүсүүд Монгол Улсад цөөн тоогоор байгуулагдаж байсан боловч энэ нь хоёр улсын хоорондох харилцаа гэхээсээ илүү цэвэр худалдаан дээр суурилсан иргэдийн харилцаа байсан юм. 1911 оны хувьсгалаар Манжийн дарлалаас ангижирсан Монгол улс АНУ-тай дипломат харилцаа тогтоох оролдлого удаа дараа хийж байсан боловч тухай бүртээ бүтэлгүйтэж байсан юм. 1921 оны Ардын Хувьсгалын дараа Монгол улс капиталист бус социалист дэглэмийг сонгож улс төр, эдийн засгийн байдлаараа ЗХУ-н хараат улс болсон учир “капиталист” АНУ-тай

10. Д. Жамбалдорж, Т. Бярзана, Д. Баярсайхан “Монгол улс Америкийн Нэгдсэн Улсын харилцаа хамтын ажиллагааны үүсэл, хөгжлийн түүхэн он жилүүд” х. 45-70 УБ, 2008

11. President Obama and President Elbegdorj Meet to Reaffirm Commitment to Partnership, http://mongolia.usembassy.gov/news_061711.html

дипломат харилцаа тогтоох оролдлогодоо цэг тавьсан юм. Энэ царцанги байдал 1960 он хүртэл үргэлжилсэн бөгөөд 1961, 1973 онд АНУ-н зүгээс БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох саналаа илэрхийлсэн боловч ЗХУ-ын эсэргүүцэлтэй тулгарч бас л бүтэлгүйтсэн юм. ЗХУ-д М.Горбачевийн эхлүүлсэн өөрчлөн байгуулалтын үеэр 1986 онд БНМАУ-д айлчилсан ЗХУ-н ГХЯ-ы сайд Э.Швердназе АНУ-тай дипломат харилцаа тогтооход тохиромжтой үе хэмээн ЗХУ-н байр суурийг илэрхийлсний дүнд 1987.01.23-нд Монгол улс АНУ-тай дипломат харилцаа тогтоов. Үүгээр хоёр улсын харилцаанд маш том эргэлт гарч 1990-ээд оны эхээр социалист системийг халсан шинэ Монголын ардчилал, эдийн засгийг АНУ дэмжиж хүмүүнлэгийн тусламж үзүүлж эхлэв. Монгол, Америкийн хооронд 1991 онд худалдааны гэрээ, 1994 онд хөрөнгө оруулалтын гэрээ хийгдэв. 1990, 1991 онуудад Монгол улсад айлчилж “гуравдагч хөрш” хэмээх томъёог гаргаж ирсэн АНУ-н төрийн нарийн бичгийн дарга Жеймс Бейкер хоёр улсын харилцааны шинэ үе шатыг эхлүүлжээ. Үүнээс хойш хоёр улсын төрийн өндөр албан тушаалтнууд удаа дараа харилцан айлчилж хоорондын харилцаагаа улам бэхжүүлж Монгол улсын нэрийг олон улсын тавцанд өндөрт өргөсөн юм. 2003 оноос Монголын зэвсэгт хүчний дайчид АНУ-н цэргийн удирдлага дор Ирак, Афганистан зэрэг дэлхийн халуун цэгүүдэд алба хааж эхлэв. 2005 онд АНУ-ын ерөнхийлөгч нараас анх удаа Монгол улсад айлчилсан Ж.Буш Монгол улс дэлхийн халуун цэгүүд рүү цэргээ илгээж байгаад гүн талархал илэрхийлж байсан юм. 2007 оны 10 сарын 24-нд АНУ, Монгол улсын хооронд 285 сая долларын өртөгтэй Мянганы Хөгжлийн Сангийн гэрээ байгуулав. Хоёр улсын харилцааны түүхийг бүхэлд нь дүгнэж үзвэл дипломат харилцаа тогтоосон үе буюу Монгол улс ардчилсан засаг төрийг байгуулсан үеэс хойш эрчимжсэн харилцаа хэдийгээр богино цаг хугацаа туулсан мэт боловч улс төр, нийгэм эдийн засаг, соёл урлаг, батлан хамгаалах зэрэг бүхий л салбарт үр дүнтэй хамтран ажиллаж олон улсын тавцанд байр сууриа баттай бэхжүүлж авчээ. Цаашид Монгол улс болон АНУ улсын хоорондох дипломат харилцаа улам бүр цэцэглэн хөгжлийн шинэ шатанд гарна гэдэгт итгэлтэй байна.

Ашигласан ном зүй

1. Жамбалдорж. Д, Бярзана. Т, Баярсайхан. Д, “Монгол улс, Америкийн Нэгдсэн Улсын харилцаа хамтын ажиллагааны үүсэл, хөгжлийн түүхэн он жилүүд” УБ, 2008 он
2. Ишжамц. Н, “АНУ-аас Монголын хувьд явуулсан бодлого, Монгол-Америкийн харилцаа (1900-1987) ” УБ, 1999 он
3. Хурметхан. М, “Монгол улс Америкийн Нэгдсэн Улсын харилцаа, хамтын ажиллагаа 1945-1999” УБ, 2000он
4. Цолмон Д. “Америкийн Нэгдсэн Улсын Түүх”УБ 2011 он
5. Эдлтон. Ж, “АНУ-Монгол Улсын Дипломат Харилцаа” УБ, 2012
6. Mongolia and the United States: A Long Way in a Short Time, <http://www.americanambassadors.org/index.cfm?fuseaction=Publications.article&articleid=244>